



ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 03/31

Жаргалант сум

「 Малжуулах хөтөлбөрийг шинэчлэн батлах,
хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Малжуулах хөтөлбөрийг шинэчлэн нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Засаг дарга (Л.Учрал)-д даалгасугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

6125010067

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдааны 09/31 тогтоолын нэгдүгээр хавсралт



НЭГ.МАЛЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

1.1.Эрдэнэт хотын иргэдийг мах, сүү, цагаан идээгээр хангахад тодорхой хувь нэмэр оруулах, байгалийн болон гэнэтийн аюулд өртөж малгүй болсон, цөөн тооны малтай залуу малчин, мал бүхий өрхөд сайн чанарын малыг малжуулах хөтөлбөрт хамруулан олгох.


1.2.Газар нутаг багатай бэлчээрийн даац хэтрэлттэй өнөө үед сумын мал аж ахуйг бодлогоор дэмжин малын тоонд бус чанарт анхааран орон нутгийн цаг уурын онцлогт тохирсон өндөр ашиг шимт мал сүргийг өсгөн үржүүлж өрхийн орлогыг нэмэгдүүлэх, бэлчээр сэргээх боломжийг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн гол зорилго оршино.

ХОЁР.СУМЫН НИЙТ МАЛ СҮРГИЙН ТОО ТОЛГОЙ

д/д	Малын тоо	Тэмээ	адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд
1	Нийт мал	40	9124	13362	26674	25367	74567
2	Хээлтүүлэгч	1	324	136	250	189	900
3	Хээлтэгч	10	3404	5926	13467	13035	35842

Үхрийн аж ахуйн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал:

д/д	Баг	Үхэр	Хээлтүүлэгч	Хээлтэгч
1	Улаантолгой	2324	13	1091
2	Жаргалант	2137	9	991
3	Дулаан-Уул	8901	114	3844
4	Дүн	13362	136	5926



2014 оноос уг хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2025 оны байдлаар 171 өрхийг 368 толгой үхрээр малжуулж ажилласан үр дүн гарсан.

ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжин эрчимжүүлэх, малын чанарт онцгой анхааран өндөр ашиг шимт цөм сүрэг бий болгон малчдын амьдралын баталгааг хангаж өрхийн орлогыг нэмэгдүүлснээр аймаг, сумын хүн амын хүнсний хэрэгцээнд эрүүл ахуйн шаардлага хангасан мах сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэн одоогийн байгаа түвшнийг тодорхой хувиар нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

- 4.1.Малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулж нэг толгой малаас авах ашиг шимийн гарцыг шинжлэх ухааны үндэслэлтэй нэмэгдүүлэх.
- 4.2.Герефорд, Сэлэнгэ үүлдрийн шилмэл 30-40 үнээ дагнан үржүүлж жишиг үржлийн аж ахуйг байгуулах.

4.3. Малчид, мал бүхий иргэдэд мал аж ахуйгаас ашиг шим хүртэх талаарх эдийн засгийн бодит тооцоо мэдээ мэдээлэл хүргэх, ур чадварыг дээшлүүлэн шинэ залуу малчдыг сургах.

4.4. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг механикуулах

ТАВ.ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Хөдөлмөрийн насны болон хөдөлмөрийн чадвартай гэр бүлийн гишүүнтэй байх.

5.2. Малын хашаа, хороо, саравч зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийн материаллаг баазтай байх. (Өвөлжөөний гэрчилгээний хуулбар болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбарыг зургаар баримтжуулж бүрдүүлэх)

5.3. Мал маллагааны уламжлалт арга ажиллагаа туршлагатай, 3-аас доошгүй жил мал малласан байх.

5.4. Хоршоо хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан ба банканд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

5.5. Хөтөлбөрөөр авсан малаа эргүүлж төлөх чадавхыг нотолсон багийн Засаг даргын тодорхойлолт.

5.6. Сумандаа сүүлийн 5 жил тогтвор суурьшилтай оршин суусан байх.

5.7. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдсан байх.

5.8. Тухайн иргэн цаашид мал маллах хэтийн зорилготой, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвартай, төлбөрөө барагдуулж дуусгаахаа илэрхийлсэн хүсэлтээ бичгээр гаргасан байх.

5.9. Хөтөлбөрийн хугацаанд буюу төлбөрийг (эргэн төлөлт) барагдуулж дуустал тус сумын харьяаллаас гарахгүй байх.

5.10. Эргэн төлөлтөө хийхдээ хөтөлбөрийн дагуу шаардлага хангасан малыг хугацаандаа багтаан бүрэн барагдуулж ЗДТГ-т хүлээлгэн өгөх.

ЗУРГАА: ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

6.1. Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг тухайн жилд хөтөлбөрт хамрагдах өрхийн тоог (квот) тогтоож, хуваарилалтыг зохион байгуулна.

6.2. Хөтөлбөрт хамрагдах иргэд өргөдөл, хүсэлтээ Засаг даргын тамгын газарт уламжилна.

6.3. Засаг дарга иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн эцэслэн шийдвэрлэнэ.

6.4. Журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан иргэнд шаардлага хангасан дөрвөн тугалтай үнээг гурван жилийн хугацаатай гурвалсан гэрээ байгуулан хүлээлгэн өгнө.

6.5. Гурвалсан гэрээний биелэлтэд ЗДТГ-н Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасаг, Санхүүгийн алба, багийн Засаг дарга нар хяналт тавьж хамтран ажиллана.

6.6. Гэрээг бүтэн 3 жилээр дуусгавар болгож, хөтөлбөрт хамрагдахаар шалгарсан иргэнтэй шинээр гэрээг байгуулан малыг шилжүүлэн хүлээлгэж өгнө.

ДОЛОО.ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА, БУСАД ЗҮЙЛ

7.1. Хөтөлбөрт хамрагдсан иргэн нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Хөтөлбөрийн хүрээнд авсан малаа зориулалт бусаар ашигласан тохиолдолд тухайн үеийн зах зээлийн ханшаар мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлнэ.

7.3.Малын арчилгаа маллагаа муу, малчны хариуцлагагүйн улмаас мал нь эндсэн, хулгайд алдсан тохиолдолд хохирлыг малчин бүрэн хариуцна.

7.4.Малын гоц халдварт, халдварт өвчний улмаас хорогдсон нь мэргэжлийн байгууллагаар нотлогдсон тохиолдолд тухайн малын нөхөн төлбөрийг малын эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

7.5.Хөтөлбөрөөр авсан малыг тухай бүр мал эмнэлэг, малын үржлийн төлөвлөгөөт арга хэмжээнд бүрэн хамруулах ажлыг хөтөлбөрт хамрагдсан малчин хариуцна.

7.6.Хөтөлбөрийн малыг ЗДТГ-н Хөдөө аж ахуйн тасаг, санхүүгийн бүртгэлд бүртгэнэ.

НАЙМ.ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

2026-2030 онд хэрэгжүүлнэ /дунд хугацааны хөтөлбөр/

ЕС.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9.1.Малын генетик нөөцийн тухай хууль

9.2.Малын эрүүл мэндийн тухай хууль

9.3.Малчны тухай хууль

9.4.Малжуулах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтын зарчмыг баримтална.

9.5 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааг тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг хариуцна.

АРАВ.ХӨТӨЛБӨРИЙН SWOT ШИНЖИЛГЭЭ:

Дотоод	
Давуу тал	Боломж
1. Малчид уламжлалт мал аж ахуйг эрхэлдэг туршлагатай 2.Мэргэжлийн боловсон хүчний хангалт сайн 3. Дэд бүтэц сайн хөгжсөн 4. Сумын нийт өрхийн 55,7 %-ийг эзэлдэг 5. Материаллаг бааз сайн	1. Өрхийн сүү цагаан идээний хэрэглээг нэмэгдүүлэх 2. Шинэ ажлын байраар хангагдах, өргөжүүлэх 3. Өөрийн эзэмшлийн малтай болох 4. Цаашид эрчимжсэн үхрийн аж ахуйг хөгжүүлэх суурь баазтай болох 5.Малчдыг мэдлэгжүүлж мэдээллээр хангах
Гадаад	
Сул тал	Эрсдэл
1. Малын тарга хүч авалт дундаас доош байх 2. Үнээ сувайрах 3. Үхэж хорогдол гарах 4. Хадлангийн гарц тааруу байх	1. Байгалийн аюулт үзэгдэлд өртөх/ ган, зуд, хүйтэн бороо, мөндөр, үер ус г.м/ 2. Мал, амьтны гоц халдварт өвчин гарах, түүнд өртөх 3. Давтамжтайгаар ган зуд болох 4. Хулгайд алдах

АРВАН НЭГ.ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шаардаг дах	Хариуцах	Үр дүн
---	-------------------------	------------------	-------------	----------	--------

		/он/	төсөв /сая.төг/	тасаг, алба	
1	Хөтөлбөрийн хүрээнд эргэлтэд байгаа үхэр сүргийн чанарыг сайжруулж үргэлжлүүлэн амьжиргааны түвшин доогуур өрхийг малжуулах	2026-2030	3.6	ХААТ, Багийн ажлын алба	Малжуулах хөтөлбөрт хамрагдсан 4-5 өрх малжиж, ажлын байртай болж, өрхийн орлого нэмэгдэнэ.
2	Хөтөлбөрийн хүрээнд шилмэл малын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	2026	14.45	ХААТ, Багийн ажлын	Иргэдэд өндөр ашиг шимтэй малын үүлдрийг сурталчлах, мэдлэг олгох
3	Герофорт, Сэлэнгэ үүлдрийн шилмэл үхрийн суурь бий болгоно.	2026-2030		ХААТ	Үхэр сүргийн чанар сайжирч ашиг шим нэмэгдэнэ.
4	Цөм сүргийг дагнан маллах малчинтай гэрээ байгуулж ажиллах	2026-2030		ЗДТГ, ХААТ	Ажлын байрыг хадгалан үлдэх
5	Цөм сүргийн малын өвөлжилт, хаваржилтад жил бүр өвс, тэжээл бэлтгэнэ.	2026	40.0	ЗДТГ, ХААТ	Малын өвөлжилтийн бэлтгэлийг хангаж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлнэ.
6	Сүргийн бүтцэд шилэн сонголт, тохируулан сонголт хийж үржлийн үр дүнд бий болсон бухан болон охин бярууг гэрээгээр малчин өрхүүдэд эзэмшүүлнэ.	2026		ЗДТГ, ХААТ	Үхэр сүргийг дотор нь шилэн сонгож үржүүлгийн ажлыг зохион байгуулна.
7	Малд үзлэг, ангилалт хийж, ээмэглэж бүртгэлжүүлэх, мэдээллийн цахим санд бүртгэх	2026	5.6	ЗДТГ, ХААТ	Ээмэгжүүлж бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн байна

АРВАН ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

- 12.1.Орон нутгийн төсөв
- 12.2.Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламж, хөрөнгө оруулалт
- 12.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж
- 12.4.Бусад эх үүсвэр

АРАВ ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- 13.1.Сумын мал сүргийн үүлдэр угсаа сайжирсан байна
- 13.2.Нэг толгой малаас авах ашиг шимийн гарц нэмэгдэнэ.

13.3. Малжуулах хөтөлбөрт хамрагдсан өрх айл богино хугацаанд малжсан байна.

13.4. Эрчимжсэн үхрийн аж ахуйн үйл ажиллагаа тогтворжих, цаашид махны үхрийн фермерийн аж ахуй эрхлэх суурь бий болсон байна.

13.5. Суманд бие даасан үржлийн цөм сүрэг бий болсон байна.

ҮР АШГИЙН ТООЦООЛОЛ

№	Үзүүлэлт	Толгой
1	Нийт олгосон үхэр	368
2	12 жилийн хугацаанд өссөн төлийн тоо	1104
3	Нийт	1472

2014-2025 онд хэрэгжиж дууссан малжуулах хөтөлбөрөөр 12 жилийн хугацаанд малчдад олгосон 368 үнээнээс нийт 1104 толгой төл хүлээн авсан. Нийт 1472 буюу сумын үхэр сүргийн 11%-ийг эзэлж, 171 өрхийг малжуулсан байна. Цаашид эргэлтэд байгаа 79 толгой тугалтай үнээг энэ хэвээр иргэдэд 5 жилийн хугацаанд буюу 2030 он хүртэл олговол нийт 395 толгой төл хүлээн авч 60 өрхийг малжуулах тооцоолол гарсан.

ЦӨМ СҮРГИЙН ТООЦООЛОЛ:

Он	БУХ	1 буханд ноогдох үнээ	Эр	Эм	Цэвэр	Эрлийз	Нийт төл
2025	20	25	225	200	128	298	425
2026	27	25	304	270	172	402	574
2027	30	25	338	300	191	446	638
2028	30	25	338	300	191	446	638
2029	28	25	315	280	179	417	595
2030	28	25	315	280	179	417	595
НИЙТ			1,836	1,628	1,039	2,425	3,464
%			13,7	12,1	7,7	18,1	26,2

Цөм сүргийн төлийн тооцооллыг 2030 он хүртэл харахад нийт үхэр сүргийн 26 хувийг эзэлж байна. Энэ нь сумын цөм сүрэг бий болгох 4.2 дахь зорилтын хэрэгжилтийг хангахад ахиц дэвшил гаргахыг харуулж байгаа.

ЦӨМ СҮРГИЙН ХЭЭЛТЭГЧИЙН СҮРГИЙН ЭРГЭЛТ:

Он	Цөм сүргийн үнээний тоо	Эр	Эм	Цэвэр	Эрлийз	Нийт төл
2025	16	8	6	4	10	14
2026	21	10	8	5	13	18
2027	28	13	11	7	17	24

2028	33	15	13	8	20	28
2029	43	20	17	11	26	37
2030	40	18	16	10	24	34
Нийт		84	71	45	110	155

Өнөөдрийн байдлаар цөм сүргийн суурьт байгаа 16 үнээ 2030 хүртэл сүргийн эргэлтэд орж төллөхөд нийт 155 төлийг хүлээн авч бойжуулна. Үүнээс цөм сүргийн үнээний тоог 30-аас бууруулахгүйгээр тооцон үлдсэн үнээг иргэдэд малжуулах чиглэлээр гэрээ байгуулан хүлээлгэн өгнө.

АРВАН ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАГНАЛТ, ҮНЭЛГЭЭ

14.1.Хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу малчин, мал бүхий иргэд, төр захиргааны холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлнэ.

14.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

14.3.Хэрэгжилт, ажлын явц, үр дүнг зурагжуулан, бодит тоо мэдээллийг нэгтгэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд жил бүрийн дөрөв дүгээр улиралд багтаан тайлагнана.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдааны
02.13.1 тогтоолын хоёрдугаар хавсралт

2025.12.11

МАЛЖУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Жаргалант сум

№	Хөтөлбөрийн зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт			Санхүүжилт	
					Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин (2026 он)	Санхүүжилт сая.төг	Санхүүжилтийн ангилал
1	Малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Айлуудыг малжуулах	6 айл 18 тугалтай үнээ	тоо	2025	11 айлыг 32 тугалтай үнээгээр малжуулсан	4 айлыг 18 тугалтай үнээгээр малжуулна	3.6	ОНХС
2	Малд үзлэг, ангилалт хийж, эзэмлэж бүртгэлжүүлэх мэдээллийн цахим санд бүртгэх	Үхэр	Эзэмгжүүлсэн малын тоо	тоо, хувь	2025	1170	Эзэмгжүүлж бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн байна	5.583	ОНХС
3	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд яаралтай тусламжийн эм бэлдмэлийн	Мал, амьтныг эрүүлжүүлнэ	Нөөцийн бүрдүүлэлт (эмийн тоо)	тоо	2025	Халдварт өвчний гаралтыг 50 хувиар бууруулсан	Малын өвчлөлийг 50 хувиар бууруулна.	3.26	ОНХС

